



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 433

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Орхон аймгийн Баян-Өндөр сумын Цагаан чулуут багийн нутаг дэвсгэрт байрлалтай, орон сууцны 7а хорооллын гаднах инженерийн шугам сүлжээний ажлын хүрээнд бий болсон нийт 223,073,889.22 (хоёр зуун хорин гурван сая далан гурван мянга найман зуун наян есөн төгрөг хорин хоёр мөнгө) төгрөгийн өртөг бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ЗАХИРГАА ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002273



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 10 ны өдрийн
433 дугаар тогтоолын хэвсрэлт

"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн
дансанд бүртгэх барилга байгууламжийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо	Барилга		Захиалагч байгууллага	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дугаар	Улсын комиссын акт дугаар	Төсөвт өртөг (төгрөг)
				Эхэлсэн	Дууссан					
1	Дулааны суваг	м	313	2013	2018					121,469,434.83
2	Дулааны шугам хоолой Ф219-325	м	636	2013	2018	БХБЯ	"Ной Крафт" ХХК	2014.01.17 02	2018.05.29 2018-01/4	80,916,940.42
3	Дулааны худаг	ш	2	2013	2018					20,687,513.98
НИЙТ ДҮН										223,073,889.22 (хоёр зуун хорин гурван сая далан гурван мянга найман зуун наян есөн төгрөг хорин хоёр мөнгө)